

“ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮМҮҮСИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН VI ОНЛАЙН БАГА ХУРАЛ БОЛЛОО

Евро-Азийн орнуудын шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх нийгэмлэгийг нэгтгэн Өвөр Байгалийн их сургуулиас уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын онлайн VI бага хурал 2021 оны 2-р сарын 25 нд зохион байгуулагдав. Олон улсын онлайн бага хурлыг Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн их сургуулийн доктор, профессор, “Экологи ба хүний эрүүл мэнд” шинжлэх ухаан боловсролын төвийн дарга, ОХУ-ын гавъяат эмч Кохан Сергей Тихонович удирдан явуулав.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дээд боловсролын хүртээмж” сэдэвт VI олон улсын онлайн хуралд Оросын Холбооны Улсын Өвөр Байгалийн Их сургууль, Бүс нутгийн инклюзив боловсролын төв, Новосибирскийн их сургууль, Донецкийн Анагаах ухааны их сургууль, АШУҮИС, ОХУ-ын Чита, Череповец хотын эрдэмтэн багш, судлаач нар оролцож, тусгай хэрэгцээт хүмүүсийн боловсрол, дээд боловсролын хүртээмж, боловсролын түвшинг дээшлүүлэх, тодорхойлох энэ талаархи мэдээлэл цуглуулах, зайн сургалтын талаархи олон илтгэл тавьж хэлэлцүүлэв. Хуралд Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн их сургуулийн доктор, профессор, “Экологи ба хүний эрүүл мэнд” шинжлэх ухаан боловсролын төвийн дарга, ОХУ-ын гавъяат эмч Кохан Сергей Тихонович боловсролын систем дэх зайн сургалтанд суралцагчдын сэтгэл ханамжийн байдал, доктор профессор Варина Ольга Александровна тусгай хэрэгцээт хүмүүсийн харилцаа хандлага,

Можайкина Людмила Борисовна онлайн сургалтын талаар, Михайловна Александра Владиславовна тусгай хэрэгцээт хүмүүсийг мэдээлэлээр хангах талаархи нийт 13 илтгэл тавигдлаа.

АШУҮИС-ийн Биоанагаахын

сургуулийн багш, АУ-ны доктор, профессор

Б.Ариунсанаа, Эм зүйн сургуулийн багш,

Эм зүйн ухааны доктор, дэд профессор Б.Баясгалан

нар “Монгол орон дахь тусгай хэрэгцээт боловсролын асуудалд” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Тусгай хэрэгцээт боловсролын хүртээмжтэй байх

асуудал нь оюутны хувь хүний болон мэргэжлийн хөгжлийн

үйл явцыг дэмжих, практик үйл ажиллагааны хамтын

оролцоог идэвхжүүлэх, боловсролын байгууллага, багш,

судлаач, мэргэжилтнүүд, гэр бүлийн хамтын оролцоог

сайжруулах зэрэг олон асуудалтай холбоотой болохыг

тэмдэглэв.

[АШУҮИС-ийн Цахим сонин 256 дугаар хүргэж байна.](#)

Линк: <https://www.flipsnack.com/9D5F97FF8D6/2021-03-22.html>-ээр хүлээн авна уу.